

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



20 24 оны 04 сарын 29 өдөр

№ SR-2024-04

Улаанбаатар хот

2023 оны санхүүгийн тайлангийн талаарх
ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн, ХасБанк ХК ("Банк")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

- Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК-ийн зөрчилгүй гэж дүгнэн баталгаажуулсан Банкны 2023 оны санхүүгийн тайлан ("2023 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан")-г Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") хянан хэлэлцээд тус тайлан нь Банкны санхүүгийн байдлыг СТОУС болон НББОУС-ын дагуу үнэн зөв бөгөөд бодитоор илэрхийлсэн гэж 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн R-2024-19 тоот тогтоолоороо дүгнэн ("ТУЗ-ийн дүгнэлт"), Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар мэдүүлсэн болохыг; мөн
- Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтын дагуу Банкны 2023 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хурал хэлэлцэн батлах бүрэн эрхтэй болохыг тус тус дурдав.

ТОГТООХ нь:

- Энэхүү тогтоолын хавсралт ёсоор Банкны 2023 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг ТУЗ-ийн дүгнэлтийн хамт баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА